

SHINE MONGOL
MABUCHI Since 2015~
FOUNDATION

*Бид танд итгэлээ.
Харин та итгэлийг маань дааж,
хойч үедээ мөн адил боломж олоорой*

Улаанбаатар хот
2020 он



ӨМНӨТГӨЛ

Шинэ Монгол Мабүчи Сан үйл ажиллагаагаа эхлүүлсний 5 жилийн ойн босгон дээр энэхүү эмхтгэлийг хүргэж байгаадаа таатай байна. Тус эмхтгэлд тэтгэлгийн сангийн эхэлсэн цаг, туулсан түүх, үйл ажиллагааны онцлог болон тэтгэлэгт оюутнууд, төгсөгчдийнхөө сэтгэгдлүүдийг тоймлон толилуулж байна.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бид Монголын 196 оюутан залууст хүсэл мөрөөдөлдөө хүрэх боломжийг олгоход гүүр болон ажилласан. Эмхтгэлээс та бүгд бидний онцлог болсон жил бүрийн тогтмол зохион байгуулдаг үйл ажиллагаанууд болох тэтгэлэг гардуулах ёслол, танилцах уулзалт, номтой уулзалт, спорт өдөрлөг, төгсөлтийн баяр, менторын тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой юм.

5 жилийн үйл ажиллагааны үр шим болсон 100 гаруй төгсөгч нар маань өдгөө улс нийгмийнхээ хөгжилд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байгаа нь бидний бахархал билээ. Төгсөгчид өөрсдийн мөрөөдлөө бодит болгохоор хичээнгүйлэн биеэ дайчилж байгааг харах нь бидэнд урам зориг өгөхийн сацуу улам сайжрах, улам ихийг хийж бүтээх хүслийг

бадраадаг. Мөн дараа дараагийн үеийн тэтгэлэгт оюутнуудад мөрөөдлөө биелүүлэх түлхэц нь болдог гэдгийг зайлшгүй дурдах нь зүйтэй болов уу.

Цаашдаа ч бид оюутан залуусдаа тэтгэлэгт оюутны хөтөлбөрөөрөө дамжуулан шаардлагатай мэдээллээр ханган зөвлөн чиглүүлж, ирээдүйд улс орноо нуруундаа үүрч явах хариуцлагатай, бие даасан боловсон хүчнийг бэлтгэхийг гол зорилгоо болгоно. Мөн үйл ажиллагааныхаа хүрээг тэлэн оюутан залуусын оролцоог хангасан төсөл хөтөлбөрүүдийг санаачлан зохион байгуулахаар ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Бидний ажлыг үргэлж дэмждэг Мабүчи олон улсын тэтгэлгийн сангийн хамт олон, дэмжин ажилладаг бүх байгууллагууддаа талархал илэрхийлж байна. Нийт тэтгэлэгт оюутнууд, төгсөгчдөдөө 5 жилийн ойн баярын мэнд хүргэхийн сацуу, цаашдын ажил хөдөлмөр, хичээл сурлагын өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн,
Б.Бэлгүн
Шинэ Монгол - Мабүчи Сангийн
нарийн бичгийн дарга





ТЭТГЭЛЭГ ИД ШИД

Юуны өмнө Шинэ Монгол - Мабүчи Санг байгуулах сайхан санаачлагыг анх гаргасан Мабүчи

Моторс компанийн анд

нөхөд, сангийн үйл ажиллагааг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүчин зүтгэсэн Монгол дахь Мабүчи тэтгэлгийн төгсөгчдийн холбооны залуус, Шинэ Монгол - Мабүчи Сангийн ажилтнууд болон энэхүү тэтгэлэгт хамрагдаж, хүсэл мөрөөдлийнхөө төлөө хичээнгүйлэн суралцаж байгаа, суралцаж төгссөн бүх оюутнууддаа 5 жилийн ойн мэнд дэвшүүлье!

Энэ баярт мөчид сайн үйлийн эхлэл болсон сайхан учралын тухай эргэн дурсаж, та бүхэнтэй хуваалцахыг хүсэж байна. Шинэ Монгол сургуулийн анхны гурван төгсөгч 2004 онд Японы их дээд сургуульд АСА-АКУА Нийгэмлэг хэмээх Төрийн бус байгууллагын тэтгэлгээр суралцах болсон юм. Тэрхүү АСА нийгэмлэгийг үүсгэн байгуулсан Мабүчи Моторс компанийн Мабүчи Такаичи ерөнхийлөгчтэй биечлэн уулзаж, ярилцах завшаан надад тохиож байв. Түүнээс хоёр жилийн дараа буюу 2006 оноос эхлэн Мабүчи Моторс компани Японд сурч буй нийт гадаад оюутанд нээлттэй “Мабүчи олон улсын тэтгэлгийг сан” байгуулснаа зарлаж, Шинэ Монголын төгсөгчдөд тусгай квот олгохоор болсноо дуулгаж билээ. Ийнхүү манай төгсөгчид жил болгон тус сангийн тэтгэлэгтэйгээр Японд суралцах боломжтой болсон ба Монголдоо эргэн ирж Мабүчи төгсөгчдийн холбоо байгуулсан юм.

Харин 2010 онд Мабүчи тэтгэлгийн сангаас Монголын дотоодын их дээд сургуульд суралцах хүсэлтэй ч, санхүүгийн боломж хязгаарлагдмал хүүхдүүдэд зориулсан тэтгэлгийн сан байгуулах санал надад тавьж, би яавал үр

өгөөжтэй байх талаар хэсэг хугацаанд бодож, олон хүнтэй зөвлөсний эцэст төгсөгчдийн холбоогоо түшиж, сангийн үйл ажиллагааг эхлүүлэхээр болсон түүхтэй. Тэтгэлгийн санг амжилттай, үр дүнтэй зохион байгуулахад зөв менежмент хамгийн чухал учраас бид төгсөгчдөө ментор болгож, тэд тэтгэлэг авах оюутныг сонгон шалгаруулах, шалгарсан оюутан бүрийг хариуцан батлан даах, дэмжин хөгжүүлэхэд биечлэн оролцож байхаар санал нэгдсэн нь хамгийн зөв шийдэл байсан юм.

Ийм учраас өнгөрсөн 5 жилийн хугацаанд Японоос санхүүжүүлсэн тэтгэлэг, зөв эздэдээ хүрч, төгсөгчдийн холбоо, сангийн ажилтнуудын хичээл зүтгэл, Шинэ Монгол сургуулийн байнгын дэмжлэгтэйгээр сонгогдсон оюутнууд маань ирээдүйдээ итгэл дүүрэн сурч, хөгжиж байгааг харах үнэхээр сайхан байдаг. Мабүчи тэтгэлгийг хүртэж Японд сурсан болон дотоодын их, дээд сургуульд сурсан залуус маань эзэмшсэн мэргэжлээрээ эх орондоо хувь нэмрээ оруулж, улсынхаа хөгжлийн төлөө урам зориг дүүрэн ажиллана гэсэн нэг үзэл бодол, итгэл үнэмшилтэй цул хүч болж, хүрээгээ тэлсээр байгааг бид ивээн тэтгэгчдэдээ бахархалтайгаар дуулгадаг юм.

Энэ хугацаанд биднийг байнга дэмжиж, зөвлөн чиглүүлж ирсэн Мабүчи олон улсын тэтгэлгийн сангийн ерөнхийлөгч Камей Шин Ичи, нарийн бичгийн дарга Оонака Шүничиоо болон сангийн ажилтнууддаа гүн талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье!

Ж.ГАЛБАДРАХ

ШМЭХ-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ,
ШИНЭ МОНГОЛ - МАБҮЧИ САНГИЙН
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ

ИТГЭЛЦЭЛ БОЛ БИДНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭХЛЭЛ...

Шинэ Монгол-Мабүчи Сан 5 нас хүрч буйд баяр хүргэе. Энэ бүгд Ж.Галбадрах захирал болон Э.Зулгэрэл захирал, сангийн үйл ажиллагаанд оролцсон бүх хүний хүчин зүтгэл бөгөөд энэ бүх хүмүүст сэтгэлийн гүнээс талархаж байна. Урьдаас төлөвлөж байсанчлан ойн баярт өөрийн биеэр оролцож, та бүхэнд мэнд хүргэхийг хүлээж байсан хэдий ч шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас оролцох боломжгүй болсон.

Би хувьдаа ойн баяр гэдэг нь өнгөрсөнд талархаж, одоо цагийн ололт амжилт болон ирээдүйн үүргийг дахин ухамсарлах өдөр гэж боддог. Үүсгэн байгуулагдсаны 5 жилийн ойг угтаж байгаа нь маш баярлууштай ч, энэ бол жил болгоны үйл ажиллагааны үр дүнгийн нийлбэр юм. Цаашид хуримтлуулсан туршлагаа ашиглаж ирээдүйд Монгол улсын хөгжлийг дээшлүүлэх гол хүч болох мэдлэг боловсролтой, ёс зүйн өндөр төлөвшилттэй иргэнийг бэлдэхийн төлөө шинэ алхмыг хийгээрэй.

УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАЛУУ ҮЕИЙНХЭНДЭЭ

Тэтгэлэгт оюутнуудад хандаж хэлэхэд, одоо дэлхий даяар шинэ төрлийн коронавирус (COVID-19) гэх урьд өмнө тохиож байгаагүй гамшиг тохиолдож байна. Хэвийн гэж бодож байсан зүйлээ хийх боломжгүй болсон өнөө цагт, бид нарын амьдрал, үйл хөдлөл нь хэрхэн байгаль дэлхийгээсээ хамааралтай байн, тэтгэгддэг байсан гэдгээ, мөн “хэврэг” зүйл байсныг мэдэрсэн байх.

Корона гэх гамшиг нь аль хэдийн олон хүнд нөлөө үзүүлж эхэлж байна. Гамшиг гэдэг нь ханзаар “危機” гэж бичигддэг ба 危 нь аюул гэсэн үг боловч 機 нь боломж, эхлэл гэсэн утгатай үг юм. Тийм учир гамшиг гэдэг нь аюул дагуулдаг ч хэдий ч боломж болж байдаг. Та бүхнийг цар тахлаас үүсэж буй сөрөг байдлыг тасалж, корона намжсаны дараах шинэ нийгмийг бүтээх хүмүүс байгаасай гэж хүсэж байна.

Миний зүгээс та нарт хүсэх зүйл бол их сургуульд сурах утга учрыг дахин сайн эргэцүүлэн тунгаахыг хүсэж байна. Өнөөдөр дэлхий дээр хүн бүр сэтгэл дотроо бүдэгхэн зовнил айдсыг тээн явж байгаа гэхэд хилсдэхгүй учир дээд боловсрол эзэмшихийн ач холбогдол утга учир нь эргэлзээтэй асуудал болж байна. Гэвч боловсрол нь үргэлж үнэ цэнэтэй зүйл хэвээрээ байх болов уу. Учир нь хичээл тус бүр тэдний онцлогоор дамжуулан өрөөсгөл хандлага, тогтсон үзэлд авталгүй зөв шийдвэр гаргаж, зөв үйлдэл хийх суурийг сурч мэдэх боломжтой учраас юм. Түүнчлэн хорвоо



КАМЕЙ ШИНЖИ

МАБҮЧИ ОЛОН УЛСЫН ТЭТГЭЛЭГИЙН
САНГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ

ертөнцийн олон талт, өөр өөрийн онцлог бүхий байдал нэмэгдсээр байна гэж бодож байна. Ийм байдал дунд сургуулиа төгссөний дараах урт үргэлжлэх амьдралд тэтгэлэгт оюутан хоорондын холбоо маш том баялаг болно. Тийм учир энэ баялгаа ашиглаж, урт удаан харилцаатай байгаарай. Өөрөөс чинь өөр үзэл бодолтой нэг үеийн олон хүнтэй харилцаж, харилцаагаа суурь болгон, ирээдүйд ирэх нийгмийг манлайлах хүмүүс болоорой гэж хүсэж байна. Энэ нь бидний хувьд баярлан бахдах зүйл гэдгийг дурдахын сацуу Шинэ Монгол-Мабүчи тэтгэлгийн сангийн үүсгэн байгуулсан зорилго утга учир юм. Төгсгөлд нь та бүгдийн эрүүл мэнд болон Шинэ Монгол-Мабүчи тэтгэлгийн сангийн гэрэлт ирээдүй сайн сайхан байхыг сэтгэлээсээ хүсэж, мэндчилгээгээ өндөрлөө.



ЗАЛУУСТ ТЭТГЭЛЭГТЭЙ СУРАЛЦАХ БОЛОМЖ БИЙ

Шинэ Монгол - Мабүчи Сангийн хамт олонд, Мабүчи олон улсын тэтгэлгийн сангийн хамт олонд, нийт тэтгэлэгт оюутнууд, төгсөгчид, зөвлөн чиглүүлэгч менторуудад 5 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

5 жилийн өмнө ямар нэг барьцаагүй, хүүгүй боловсролын зээлийг Монголд эхлүүлсэн нь шинэлэг зүйл байсан юм. Үүний дээр, Шинэ Монгол сургуулийн Японд суралцаж төгссөн төгсөгчид тэтгэлэгт оюутнуудыг хариуцан авч, зөвлөн чиглүүлдэг нь тус тэтгэлгийн хамгийн том онцлог гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу. Түүний зэрэгцээ, улирал тутамд тэтгэлэгт оюутнууд зөвлөн чиглүүлэгч нарынхаа хамт цуглан үнэт зүйлийн үзлээ нэгтгэж, яриа илтгэл сонсон, тэмцээн уралдаан зохион байгуулдаг нь тус тэтгэлгийн сангийн эргэх холбоог сайжруулсан болов уу гэж боддог. Салбар бүрийн оюутнууд нэг дор цуглаж, бие биенээсээ харилцан суралцаж, хамтдаа урагш хөгжиж байгааг энэ 5 жилийн хугацаанд би ойроос харж ирлээ. Шинэ Монгол - Мабүчи Сангийн оюутнууд нэгэн хамт олон болон бүрэлдэж, ойртон дотносож, эерэг сэтгэлгээ, эерэг соёлыг бүтээж буйг харахад сайхан байдаг. Тус сангийн оюутнуудаас эдүгээ надтай хамт ажиллаж, ойр харилцдаг Ангирмаа, Алтанбаяр, Ганбилэг, Сувдаа, Эрдэнэ-Очир, Очиргарьд гээд олон төгсөгч, оюутнууд байна. Та бүхэндээ энэ завшааныг ашиглан талархал илэрхийлье.



П.НАРАНБАЯР

ШИНЭ МОНГОЛ - МАБҮЧИ САНГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /2015-2020/,
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Тэтгэлэг гэдэг боломж. Оюутан хүн боломжоор хангагдсанаар хүсэл мөрөөдлөө биелүүлэх хүчийг олж авдаг. Авсан тэтгэлгээ ажил дээр гарсан хойноо буцаан төлж, өөрөө тэтгэлэг олгогч болсон тэтгэлгийн сангийн төгсөгчдөөрөө би цаг ямагт бахархаж явдаг аа. Хариуцлагаа биелүүлж, монгол хүний зөв зан чанар, зөв өвийг бүтээж байгаа та бүхэн бол шинэ эрин цагийн эзэд билээ.

Тус сангийн үйл ажиллагааг жигдэлж, зөв зүйтэй залж ирсэн үүсгэн байгуулагч Ж.Галбадрах багш, жил бүр хүрэлцэн ирж оюутнуудтай уулзан урам хайрлаж ирсэн Мабүчи олон улсын тэтгэлгийн сангийн ерөнхийлөгч Камэй Шинжи, гүйцэтгэх захирал Оонака Шүничироо, сангийн ажлыг амжилттай удирдаж ирсэн Зулгэрэл багш болон үе үеийн төгсөгч нартаа чин сэтгэлийн угаас талархал илэрхийлье.

**Монголын боловсрол
мандан бадраг.**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ

Мабүчи олон улсын тэтгэлгийн санг үүсгэн байгуулагч Мабүчи Такаичи болон Кэничи нар хамтран 1954 онд Мабүчи мотор ХХК-г үүсгэн байгуулж, улмаар тус компанийн захирал, ерөнхийлөгч, хүндэт ерөнхийлөгчийн албыг тус тус хашиж байв. Компания удирдах үедээ нийгмийн хариуцлагыг ихэд чухалчлан, техникийн сайжруулалтыг байнга эрэлхийлдэг байсан бөгөөд бага өртөгт моторыг зах зээлд нийлүүлэх нь нийгэмд хүлээсэн хариуцлага гэдэг санааг баримталдаг байв. Худалдан авагчийн нэрлэсэн үнээс доогуур үнээр бүтээгдэхүүнээ борлуулж, худалдааны зөвлөх ажилтныг алмайруулсан гэх яриа ч бий. Мөн Мабүчи мотор ХХК нь автомат утас ороогчийг дотооддоо зохион бүтээснээр үйлдвэрлэлийн хөгжүүлэлтийн суурийг тавьсан байдаг.

Бизнесээр олсон мөнгөө юунд

ашиг тустай зарцуулах, тэр нь ямар байдлаар, хаана хэрэгжүүлж болох талаар Мабүчи Такаичи бодож байхдаа олон улсын тэтгэлэгт сан үүсгэн байгуулах бодол толгойд нь орж иржээ. Ингээд боловсрол бол хүн төрөлхтний хөгжлийн үндэс хэмээн үзэж оюутан залуусыг эрх тэгш, чанартай боловсрол эзэмшихэд нь дэмжин туслах зорилгоор 2005 онд “Мабүчи олон улсын тэтгэлгийн сан” (Mabuchi International Scholarship Foundation - MISF) үүсгэн байгуулсан.

Өнөөдөр тус сан маань Японы Чиба аймгийн Мацүдо хотноо байрладаг бөгөөд жил бүр 100 гаруй Япон улсад суралцаж байгаа Азийн орны оюутнуудад сургалтын төлбөр, амьдрах зардлыг бүрэн олгодог, буцалтгүй тэтгэлэг юм. Мөн уг сангаас тэтгэлэг авсан 101 Монгол оюутан байдаг.



ШИНЭ МОНГОЛ - МАБУЧИ САН

2015 оны 8 сард Мабүчи олон улсын тэтгэлгийн сан, Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль (ЕБШМС) болон Монгол дахь Мабүчи тэтгэлгийн төгсөгчдийн холбоо (МА-MISA)-тай хамтран Шинэ Монгол-Мабүчи Санг үүсгэн байгуулав.

Энэхүү тэтгэлэг нь гурван талын харилцан ойлголцол, итгэлцлийн дүнд бий болсон. Монголдоо анхдагч гэж хэлж болох барьцаагүй, хүү шимтгэлгүй эргэн төлөгдөх нөхцөлтэй тэтгэлэг юм. Тэтгэлэгт оюутнууд 2 болон 4 жилийн хугацаанд жил бүр 1500 ам.долларын сургалтын төлбөрийн тэтгэлэг авдаг.

Мөн менторын тогтолцоог нэвтрүүлснээрээ онцлогтой.

ШИНЭ МОНГОЛ - МАБУЧИ САНГИЙН ЗОРИЛГО

Монголын дотоодын улсын болон хувийн их дээд сургуульд суралцаж байгаа суралцах чин хүсэл эрмэлзэлтэй оюутныг дэмжих, нэгдэн нийлж улс эх орныхоо төлөө сурсан бүхнээ харамгүй зориулах сэтгэлтэй хамт олныг төлөвшүүлэх зорилготой. Мөн залуусын дунд урам, итгэлцэл уламжлан дамжиж, ирээдүйн монгол залуучууд бие даасан, өөртөө болон бусдад итгэх итгэлтэй, хариуцлагыг багаасаа ухамсарласан иргэд болж төлөвшихөд бага ч болов хувь нэмэр оруулах зорилготой үүсгэн байгуулагдсан юм.

Мөн тэтгэлэг олгох замаар Монгол улсыг хөгжүүлэх, чанартай боловсон хүчин бэлдэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор үүсгэн байгуулагдсан. Энэ зорилгын хүрээнд тэтгэлэг авсан оюутан ирээдүйд тэтгэлэг олгогч болон хувирах юм. Энэ нь өнөөдөр Монголын нийгэмд дутагдаад байгаа итгэлцэл, хариуцлага хэмээх ухамсрыг суулгахад тодорхой хэмжээнд тус нэмэр оруулна гэж үздэг.

Тэтгэлгийн сангийн гол зарчим нь “итгэлцэл” юм. Оюутанд өгч буй тэтгэлгээр дамжуулж итгэл, урам өгч цаашид илүү сайн суралцах, нийгэмд амжилттай бие хүн болох хүсэл тэмүүлэл, үүрэг хариуцлагаа ойлгоход нь туслах нь нэн тэргүүний зорилго юм.

Түүнчлэн эргэн төлөх нөхцөл нь ямар нэг ашгийн төлөө бус. Харин эхний оюутнуудаас ирэх эргэн төлөлт нь “тэтгэлгийн сан” болон хуримтлагдаж, дараа дараагийн оюутнуудад тэтгэлэг болон очиж эргэлт үүсгэх юм. “Эргэн төлөгдөх тэтгэлэг нь нийгэмд хариуцлагатай, бие хүнийг бэлдэх зорилготой”. Мабүчи тэтгэлэг нь хатуу дүрэмтэй гэрээ, бичиг баримт бус дан ганц “ИТГЭЛЦЭЛ” дээр тогтож буйгаараа онцлог.



MABUCHI MOTOR CO., LTD.

Өнөөгийн дэлхий дээр зах зээлийн эдийн засаг нэвтрэн орсноор олон хөгжиж буй орнуудын эдийн засаг гайхалтай өсөлттэй байгаа. Гэсэн хэдий ч баян, ядуугийн ялгаа хөшигний ард улам бүр нэмэгдэж байгаа нь бас үнэн юм. Үүнийг үл тоомсорлосноор ядуурлын асуудал болон түүнээс гарч буй гэмт хэргүүд ихсэхэд нөлөөлнө хэмээн эмээж байна.



Япон улс дайны ялагдлаас гайхамшигтайгаар сэргэн мандалтыг хийж, эдийн засгийн хувьд АНУ-ын дараа жагсах хөгжингүй орон болсон бөгөөд баян ядуугийн хоорондох ялгаа нь ялимгүй бага билээ. Энэ нь тухайн үеийн үндэсний бодлоготой холбоотой ба ядуу байсан ч бүгд ижил тэгш суралцах эрхтэй байж, тодорхой хэмжээний боловсролтой болдог байсан нь улсын чадамжийг дээшлүүлж байсан. Тухайн үед сурж байсан хүмүүсийн хүчин чармайлт болон хичээл зүтгэлийн ачаар улс хөгжиж, эдийн засгаар дэлхийд хоёрт үнэлэгдэх хүртлээ дэвшиж чадсан юм. Тийм болохоор хөгжингүй улсын нэг болсон манай улсын хийх ёстой зүйл бол Ази тивд ядуурлыг багасгаж, түүний төлөө боловсролыг нь олгоход дэмжих нь нэн чухал хэмээн бодож байна.

Тиймээс бага ч гэсэн хувь нэмрээ оруулах үүднээс тухайн улсын иргэд өөрсдийн гараар үргэлжлүүлэн авч яваасай, боловсролоор дамжуулан биеэ даасан байдлыг нь дэмжих үүднээс бусад орны залуучуудыг Япон улсад суралцахыг дэмжин ажиллаж хүний нөөцийг хөгжүүлэх хэлбэрээр Азийн орнуудын хөгжлийг хурдасгахад хувь нэмрээ оруулахыг хичээж байна. Цаашдаа тухайн улс орнуудад тэтгэлгийн сан байгуулан, түүний үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана гэж бодож байна.

Бидний үйл ажиллагааны утга учир нь тухайн хамаарч буй улс орнуудад ойлгогдох цаг ирж, бидний сэтгэл болох нарийн булаг маань томоохон гол болон Ази болон түүнээс халин гарч дэлхий дахинаа амьдрахад таатай, эв найрамдалтай болгож чадвал бидний сангаа байгуулсны утга учир биелэгдлээ гэж үзэх билээ. Бидний сэтгэл хэзээ нэгэн цагт тус улсуудад хүрч, цаашлаад дэлхийд тархаж, одооноос илүү таатай амьдрах ертөнц бий болгоход хувь нэмэр оруулна гэж хувьдаа итгэж явдаг.

МАБУЧИ КЭНИЧИ
МАБУЧИ САНГИЙН ҮҮСГЭН
БАЙГУУЛАГЧ



15 жилийн өмнө Шинэ Монгол ахлах сургуулиа төгсөөд Япон улсын Шиншүгийн Их Сургуулийн “Барилга, дэд бүтцийн инженерчлэл”-ийн ангид элсэхдээ Мабүчи Моторс компанийн АСА-АКУА хэмээх байгууллагаас тэтгэлэг авч байлаа. Тийм их “мөнгө” (тэтгэлгийн мөнгөн дүнтэй батламж байсан) барьж үзэх нь байтугай зүүдэлж ч үзээгүй би гэдэг хүн Ж.Галбадрах багшийнхаа ярианаас “тэтгэлэг” хэмээгч шидтэй зүйлийн талаар сонсож байснаас биш жирийн амьдрал дээр “май хө, мөрөөдлөө биелүүлээрэй” гэхэд нэг л итгэж өгөөгүй.

Намайг бага сургуульд ороход аав ээж, эмээ өвөөгийнхөө ачийг “онц” сурвал хариулна гэж хэлдэг учрыг ойлгодоггүй байсан юм. Харин тэтгэлэг авч их сургуульд суралцах үедээ жинхэнээсээ ойлгов. Бидэнд өндөр боловсрол эзэмшихэд дэмжин тусалж байгаа нь биднийг “хөгжиж буй” хэмээх тодотголтой Монгол улсаа ирээдүйд сайн сайхан авч явах, дэлхийн бусад улстай хөл нийлүүлэхэд хүч болох энгийн нэгэн мөрөөдлийг минь дэмжиж, биелүүлэх эздийг нь бүтээж өгсөн хэрэг байлаа. Уг чанартаа сайн боловсрол гэдэг ард түмнийг, улс орныг, мөн дэлхийг сайн сайхан амьдруулах үндэс гэдгийг биднээс урд алхаж яваа “сэнпай” Япон улс түрүүлэн харж, ардаа яваа бидэнд зааж өгч буй хэрэг гэж ойлгосон.



2015 онд Монголын залууст боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх Шинэ Монгол – Мабүчи Сан үүсгэн байгуулагдаж, жил бүр их, дээд сургуулийн 30 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгохоор болсонд би туйлаас их баяртай байлаа. Япон улсад хамт тэтгэлэгт хамрагдаж байсан ШМАС-

ийн бүх төгсөгчид маань энэ үйлсийг эхлүүлэхэд хамтран зүтгэж, Монголд өмнө нь хэзээ ч байгаагүй тэтгэлгийн системийг бий болгох, таниулахаар ажиллаж эхэлсэн бөгөөд улмаар “Монгол дахь Мабүчи тэтгэлгийн төгсөгчдийн холбоо”-г байгуулсан юм. Энэхүү холбооны маань хамгийн том зорилго, гол онцлог бол “мэнтор” хөтөлбөр хэрэгжүүлдэг явдал бөгөөд Шинэ Монгол – Мабүчи Сангийн тэтгэлгийг авч суралцаж буй оюутан дүү нартаа хичээл сургууль, ажлын гараагаа эхлэх зэрэгт нь өөрсдийн туулсан туршлагаасаа зөвлөгөө өгч нэг утгаараа жинхэнэ “эрдэм номын ах дүүс” бололцдог явдал байлаа. Ж.Галбадрах багш бүр биднийг “амьдралын ах дүүс” ч гэж нэрлэдэг юм. Өнөөдөр 190 гаруй залуус энэхүү тэтгэлгийг авсны ачаар илүү өөртөө итгэлтэй, илүү хичээл чармайлттай, илүү амжилттай суралцаж, ажлын гараагаа ч амжилттай эхэлж байна.

Э.ЦЭНДСҮРЭН

MAMISA АНХНЫ ТЭРГҮҮН,
ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ БОЛСОН ОЮУТАН, ЗАЛУУСДАА БАЯРЛАЛАА

Шинэ Монгол-Мабүчи сангийн 5 жилийн үйл ажиллагаа нь 2015-2020 онд сангийн нарийн бичгийн даргаар ажилласан Э.Зулгэрэлийн хичээл зүтгэлтэй салигүй холбоотой билээ. 2020 оны 2 сарын 1-нээс Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургуулийн захиралаар томилогдон ажиллахын сацуу Шинэ Монгол - Мабүчи сангийн гүйцэтгэх захирлаар мөн ажиллаж байна. 5 жилийн ойг угтан МАМИСА-н тэргүүн Н.Болормаа, сангийн ментор төгсөгч хариуцсан ажилтан Б.Содбилэг нар сангийн 5 жилийн түүхийг эргэн харж амжилт ололт, дурсамж сэтгэгдлээ хуваалцан ярилцлаа.



А: Та анх тэтгэлэгийн сан байгуулагдах талаар сонсоод ямар сэтгэгдэлтэй байсан бэ? Энэ ажлыг хүлээн авч байсан үеэсээ дурсахгүй юу.

Э.З: Анхны сэтгэгдлийн хувьд маш их баяртай байсан. Тэтгэлгийн ач холбогдол, үнэ цэнэ, тэтгэлэг хүнийг

яаж өөрчилж чаддагийг өөрийн биеэр мэдэрсэн хүний хувьд, энэ тэтгэлгийг олон оюутан залууст олгон, адилхан мэдрэмжийг мэдрүүлэн, олон хүний амьдрал өөрчлөгдөөсэй гэж хүссэн. Мөн тэтгэлгийн сангаараа дамжуулж, ганцаараа хийж чадахгүй олон зүйлсийг хийж бүтээн Монголынхоо нийгэмд хувь нэмрээ оруулж, үнэ цэнийг бүтээх боломжтой гэж бодсон. Тэр л сэтгэлээр ажлаа анх хүлээн авч өнөөдрийг хүртэл үргэлжлүүлж байна.

Н.Б: Галаа багшийн тэтгэлгийн тухай яриа Шинэ Монгол төгсөгч бидний сэтгэлд гүн хоногшин үлдсэн байдаг. Ялангуяа тэтгэлэг, оюутан залуусын амьдралд ямар нөлөө үзүүлдэг талаар дурдахгүй байхын аргагүй.

Э.З: Галаа багшийн ярианаас бид тэтгэлгийн утга учир, үнэ цэнэ түүнийг дагаад ирэх хариуцлагыг гүн гүнзгий ойлгож мэдэж авдаг. Тэр хариуцлага нь эргээд биднийг эрч хүчтэй, илүү их хичээх, хийж бүтээх хүсэл эрмэлзлээр дүүрэн байлгадаг гэж бодож явдаг.

Б.С: Санг анх Монголд үүсгэн байгуулсан үеийн түүхийн талаар хуваалцана уу.

Э.З: Бид анх сангийн үйл ажиллагааны талаар ярилцаад менторшипийн тогтолцоог нэвтрүүлэхээр шийдсэн. Энэ нь нэг ёсондоо нэр хугарахаар яс хугар гэдэгчлэн, хуурай ах дүүгийн харилцаанд тулгуурлан итгэлцлийг гол болгосон. Тухайлбал, Зулгэрэл гэдэг хүн миний ментор болоод, надад итгээд, санаа тавиад намайг амжилттай байлгахад анхаарч байна. Энэ хүнд би

худлаа ярьж болохгүй, хэлсэн амандаа хүрч итгэлийг нь дааж амьдрах ёстой юм байна гэдэг бодол санаатай болж эхлэх нь өөрөө гол утга учрыг агуулдаг.

Үүнээс гадна, сангаас зохион байгуулдаг үйл ажиллагаа тус бүр өөр өөрийн онцлогтой. Эдгээрээр дамжуулан эргэн төлөлт хийснээрээ та ямар хүн болон төлөвшиж, таныг ямар ирээдүй хүлээж байна вэ гэдэг талаарх яриаг түлхүү зохион байгуулдаг. Энэ нь ч эерэгээр нөлөөлсөн гэж бодож байна. Нийгмийн амьдралд оролцоход хариуцлага, өөртөө итгэх итгэл, мэдлэг чадвар юу юунаас чухал. Оюутан залуусыг нийгэмд гарч сайн боловсон хүчин болоход чиглэгдсэн ажлуудыг хийхсэн гэж хичээж ирсэн.

Б.С: Тэтгэлгийн сангийн үйл ажиллагааг гардан хийж байсны хувьд энэ ажлын хамгийн сайхан нь юу байдаг вэ?

Э.З: Хамгийн сайхан зүйл нь тухайн оюутны өсөлт хөгжил, төлөвшил гэх мэт бүх зүйл нүдэн дээр ил харагдаж байдаг. Тэрнээс их урам зориг авдаг. Жишээлбэл: Уулзалтын үеэр оюутнууд “Манай найз нар уулзалтын дараах өдрүүдэд намайг бүр шал өөр хүн болчихсон байна гэсэн” гэж сэтгэгдлээ хэлдэг нь бидний үйл ажиллагаа үр дүнтэй байгааг илэрхийлдэг юм болов уу гэж боддог. Мөн сурлагын дүн тийм ч сайн байгаагүй нэгэн нь маш их хичээж, өөрийнхөө үүрэг хариуцлагыг ухамсарлаад, тэтгэлэгт оюутан гэдэг өөрийн нэр төрийг хамгаалахын төлөө ментор ах эгч нартаа өгсөн амлалтаа биелүүлэхийг хичээн, өөрийгөө

дайчилдаг тэр дүр зураг нь маш их эрч хүч өгдөг. Энэ нь тухайн хүүхдийн дүн дээр ч, зан харилцаан дээр нь ч илэрч байдаг. Хүүхэд бүр өөр өөрийн онцлогтой, харилцаа хандлагын хувьд харьцангуй өөр байдаг. Харьцааны хувьд асуудалтай хүүхдийг менторлох тохиолдол ч байдаг. Оюутнууд маань их санаачлагатай болдог. Мэддэг чаддаг зүйлээрээ сангийнхаа үйл ажиллагаанд ороод туслаад явдаг оюутнууд олон байдаг. Залуустайгаа хамтран ажиллах, тэдний өсөлт, хөгжлийг бодитоор дэргэдээс нь харж чаддаг нь хамгийн сайхан санагддаг.

Н.Б: Оюутан менторын харилцаанд юу хамгийн чухал байдаг вэ?

Э.З: Мабүчи сангийн гол онцлог бол мэдээж Менторшип тогтолцоо. Ялангуяа менторууд нь Шинэ Монгол сургуулийн төгсөгчид байдаг гэдгээрээ онцлогтой. Оюутнуудын хувьд, гадаад дотоодын их дээд сургуульд сурч төгссөн, нийгэмдээ өөрийн байр сууриа олчихсон ах эгч нартайгаа холбогдон хуурай ах, эгч дүүсийн холбоотой болно гэдэг нь давуу тал болдог. Мөн ойролцоо насны залуучууд бие биенээ дэмжиж туслан, нэг нэгнээсээ урам зориг авч явдаг гэдгээрээ оюутан менторын хоорондын харилцаанд маш их үнэ цэнийг авчирдаг юм болов уу гэж бодож байна.

Б.С: 5 жилийн хугацаанд сан маань юуг зорьж, түүнийгээ хэр амжилттай биелүүлсэн гэж та дүгнэж байна вэ?

5 нас хүрнэ гэдэг нь 5 настай балчир үе гэж хэлж болно. Цаашид улам өсөн дэвшиж, улам олон хүнд хүрч, улс орныхоо хөгжилд илүү их үнэ цэнийг бүтээх, танигдах боломж их байгаа гэж харж байгаа. Энэ хугацаанд олон оюутнуудад тэтгэлэг олгон эхнээсээ үр шим нь гарч эхэлж байна. Нийт 7 оюутан, тэтгэлгийн эргэн төлөлтөө хийж дууссан байна. Өнгөрсөн оны 8 сарын байдлаар эргэн төлөлт 96 хувьтай байгаа. Харин сан маань 5 жилийн хугацаанд юуг зорьсон тухайд оюутнууд тэтгэлгээ хариуцлагатайгаар буцаан төлдөг ухамсартай байгаасай гэж хамгийн их хүссэн. Эргэн төлөлтийн хувийг харахад өндөр хувьтай байгаа. Энэ нь зорьсон зүйлийн маань үндсэн илэрхийлэл, ажлын үр дүнг илтгэх гол үзүүлэлт гэж бодож байна. Мэдээжийн хэрэг, сангийн үйл ажиллагааг анх эхлүүлж байх үед саад бэрхшээлүүд олон байсан. Гэхдээ тэр болгоныг олон хүний хамтын ажиллагаа, хүч хөдөлмөрөөр даван туулаад ирсэн. Үүнд гол үүрэг гүйцэтгэсэн хүмүүс нь тэтгэлэгт оюутнууд өөрсдөө байсан гэдгийг онцгойлон дурдмаар байна. Оюутнуудын өөрсдийнх нь хүчээр сангийн үйл ажиллагаа тогтвортойгоор хөгжиж чадсан. Сангийн хувьд ажиллах хүн хүч дутмаг байдаг боловч оюутан, менторууд хувь нэмрээ их оруулсан. Бүгдэд нь талархсан сэтгэлээ илэрхийлмээр байна. Мэдээж Шинэ Монгол сургуулийн дэмжлэг байгаагүй бол сан маань үүсэн бий болохгүй байсан. Шинэ Монгол сургууль болон МАМИСА, гол хөрөнгө оруулалтыг хийсэн Мабүчи олон улсын тэтгэлгийн сан гэсэн 3 талын үүрэг оролцоо чухал юм.

Тэтгэлгийн хувьд бид өдий хүртэл өөрчлөөгүй ганц зүйл нь тэтгэлэгт оюутанд тавих шаардлага, шалгуурыг огт бууруулаагүй явдал юм. Энэ нь үнэ цэнэ, чанараа хадгалахыг анхаардагтай холбоотой. Цаашдаа улам илүү чанаржуулахад анхаарлаа хандуулах бөгөөд улам олон хүүхэд авахаар шалгуурыг бууруулах төлөвлөгөө бол байхгүй. Чанараа хадгалан эсээ бичүүлэх, ярилцлага хийх, 3.2-оос дээш дүн шаарддаг байснаараа өөртөө илүү өндөр шаардлага тавьдаг, хариуцлагатай, ухамсартай, зорилготой, мөрөөдөлтэй оюутнууд манай санг зорин ирдэг гэж боддог. Тэр ч утгаараа Мабүчи сангийн тэтгэлэгт оюутан гэдгээрээ төгсөгчдийн маань нийгэмд эзлэх байр суурь, үнэ цэнэ өсдөг байгаасай гэж хүсдэг. Түүгээр ч зогсохгүй Шинэ Монгол Мабүчи сангийн тэтгэлэгт оюутан гэхэд итгэж болохуйц, хариуцлагатай хүн гэдгийн баталгаа болдог байхыг чин сэтгэлээсээ хүсч байна.

Нийт төгсөгчид, менторууд, оюутнууд, хамтран ажиллаж ирсэн их дээд сургуулиуд, хамт олон байгууллага, та бүхэндээ ШММС-ын 5 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж цаашид ч сангийн үйл ажиллагааг дэмжин бидэнтэй хамтран монголын хойч ирээдүй болсон оюутан залуусын төлөө олон сайхан түүхийг хамтдаа бүтээхийг хүсье.

3.ЗУЛГЭРЭЛ

ШИНЭ МОНГОЛ - МАБҮЧИ САНГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ,
ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



Та бүхэндээ 3-р үеийн тэтгэлэгт оюутан Энжхингийн “Medium.com” сайт дээрх хувийн тэмдэглэлээс хүргэж байна.

ШИНЭ МОНГОЛ МАБУЧИ САНГИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР, АМЬДРАЛД МИНЬ БИЙ БОЛГОСОН ҮНЭ ЦЭНЭ



“Хуваалцахад хайран атлаа хуваалцахгүй орхивол бүр ч хайран санагдах тэр зүйл л жинхэнэ үнэ цэнэтэйд тооцогдох болов уу.”

Шинэ Монгол Мабүчи сан бол яах аргагүй үнэ цэнэтэй гэх энэ ангилалд зүй ёсоор багтах билээ. Юуны учир энэхүү ангилалд багтаан сэтгэж хүндлэн бодож буй учраа сийрүүлэн буулгавал, 2017 оны наймдугаар сарын сүүл үе, тэр үеийн байр байдлаа төдийлөн нэг бүрчлэн санахгүй байгаа ч “тэтгэлэг” хэмээх үгийг 100% мөнгөтэй холбон боддоггүй байсандаа л одоо хүртэл талархана. “Шинэ Монгол Мабүчи сан”-гийн тэтгэлэг эргэн төлөгдөх нөхцөлтэй гэдгээрээ бусад тэтгэлэг олгодог хэмээх сангуудаас ялгарна. Энэ өгүүлбэрийг уншсан нийт хүмүүсийн 40% орчим нь “өө, тэгвэл зээлээс ялгарахгүй нь” хэмээн үлдсэн 60%-даа маш том боломжийг үлдээгээд, өөрсдөдөө байсан боломжоо түлхэж байгаагаа анзааралгүй холддог. Тухайн үед аз болж би тэрхүү үлдсэн 60%-д багтаж чадсан.

“Энэхүү тэтгэлэг материал бүрдүүлэх үеэсээ л намайг дэмжиж байсан гэдгийг одоо л харж байна.”

Тухайн үед “Миний ирэх 10 жил ба мөрөөдөл” сэдвээр эсээ бичихдээ өөрийгөө бүтээж байсан, одоо ч зүг чигээ алдсан үедээ түүнийгээ уншиж мөрөөдөл рүүгээ тэмүүлэх хүслээ асаадаг. Яг л эвлүүлдэг тоглоомын нэг хэсэг хаа нэгтээгээс гараад ирсэн мэт, одоо ч тэрхүү эхлэлийг сануулдаг нь, бүтээдэг нь гайхалтай. Хүн амьдрах явцдаа том зорилгыг өвөртөлдөг, түүндээ хүрэх жижиг зүйлсийг хийдэг, хийсээр хийсээр эцэст нь өнөөх том зорилгоо умартан, жижиг зүйлсээ л аргалсаар урт удаан цаг хугацааг өнгөрөөчихсөн байдаг. Үүнээс өөрийгөө хамгаалж, бага зэрэг өндөрлөгөөс өөрийгөө харах хэрэгтэй боловч ингэх хэрэгтэй гэдгээ ихэнхи тохиолдолд хүмүүс анзаарч чаддаггүй. Хэрвээ чи ганцаараа бол өөртөө дүгнэлт өгөөд хичээхийг оролдох л байх, гэхдээ чамд Мабүчи сангийн хамт олон байгаа бол тэд чамайг урсгалдаа хөвөн дэмий суух үед чинь татаж гаргаад урагшлах ухаан болоод үзэл хандлагыг өгөх болно.

ТЭТГЭЛЭГ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ

Жил бүрийн 10-р сарын эхээр оюутнууддаа тэтгэлэг гардуулах ёслолын үйл ажиллагаа болдог бөгөөд тус үйл ажиллагаанд Шинэ Монгол – Мабүчи Сангийн удирдлагууд маань оюутан залууст хандан үг хэлдэг. Үүнээс гадна шинээр тэтгэлэг гардан авсан оюутнууд болон гэр бүлийн төлөөлөл нь өөрсдийн сэтгэгдэл ээ илэрхийлдэг.

ТАНИЛЦАХ УУЛЗАЛТ

Тус уулзалтын зорилго үе үеийн тэтгэлэгт оюутнууд хоорондоо танилцах, харилцаа холбоо тогтоох болон тус жилийн шинэ тэтгэлэгт оюутнууд ментор ах эгч нартайгаа танилцдаг бөгөөд менторуудад цаашид хэрхэн зөвлөгөө өгч ажиллах чиглэл авдаг. Уулзалт нь 11 сарийн сүүлээр болдог бөгөөд оюутан залууст хэрэгцээт мэдээлэл өгөх зочдыг урьдаг.

НОМТОЙ УУЛЗАЛТ

Энэхүү уулзалтад ЭМОС клубийн орчуулан гаргасан ном бэлэглэн, тэмдэглэл хөтлүүлдэг. Оюутнуудын явуулсан номын тэмдэглэлийг тусгай баг гарган хамтран уншиж, шилдэг тэмдэглэлийг Номтой уулзалтын өмнө шалгаруулж -шилдэг тэмдэглэл хөтлөгч"- өөр шалгарсан оюутнууд илтгэл бэлдэж уулзалтын эхэнд танилцуулдаг.



СПОРТ ӨДӨРЛӨГ

Энэхүү өдөрлөгийн зорилго нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хоорондын харилцааг илүү сайжруулж, бие биеэсээ суралцах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх билээ. Спорт өдөрлөг нь сагс, гар бөмбөг, ширээний теннис, шатар, олс таталт гэсэн 6 төрлөөр явдаг бөгөөд жил бүрийн ялагчид шилжин явах цомыг гарддаг билээ.

ГУРАВЛАСАН УУЛЗАЛТ

Энэхүү уулзалтаар бид тухайн жилийн их сургуулиа төгсөж байгаа тэтгэлэгт оюутнуудтай уулзаж дипломын сэдэв, явц, шалгалтын бэлтгэл, төгсөөд орох ажлын төлөвлөгөө, ажилд ороход шаардлагатай зүйлс, анкет, ярилцлагад хэрхэн бэлдэх талаар ярилцаж, зөвлөгөө өгөх зорилготой юм.

ТӨГСӨЛТИЙН БАЯР

Шинэ Монгол – Мабүчи Сангийн бүх тэтгэлэгт оюутнууд оролцдог бөгөөд тус жил төгсөж байгаа оюутнууд маань сурч байх хугацаандаа ойлгож мэдсэн зүйлсээ хуваалцах, төгсөгчдийн дипломын ажил, судалгааны ажилтай танилцах, тэтгэлгийнхээ оюутан дүү нартаа туршлагаасаа хуваалцах зорилготой билээ.





Шинэ Монгол-Мабүчи сан нь оюутнуудаа зөвхөн санхүүгээр дэмжих бус, оюунаар тэтгэх үүднээс ЭМОС клуб болон шилдэг хэвлэлийн газруудын орчуулан гаргасан номнуудыг уншуулдаг. Тухайн

номынхоо тухай тэтгэлэгт оюутнууд болон менторууд нь хамтран ярилцаж, бие биенийхээ үзэл бодлыг сонсох мөн багаар хамтран ажиллах чадварыг сайжруулах зорилготойгоор энэхүү үйл ажиллагааг зохион байгуулдаг.

УНШИХ НОМ

АМЖИЛТАД ХҮРЭХ ГАЛ ЭРМЭЛЗЭЛ

Г Хүн болгон мөрөөдөлтэй байж түүнийхээ төлөө тууштай тэмцэж чаддаг байх ёстой. Манай тэтгэлгийн сангаас шинэ оюутнууддаа зүрх сэтгэлийнхээ галыг асааж, шаргуу зүтгэх эрмэлзэлтэй болоосой гэж Японы зохиолч Инамори Казүогийн “Амжилтад хүрэх гал эрмэлзэл” номыг эхний жилд нь уншуулдаг.



“Үзэл хандлагыг төлөвшүүлэх нь таны хичээл зүтгэл, үлгэр жишээнээс шууд шалтгаална. Тиймээс бүтээлч үзэл санаа, хэтийн зорилго, өөдрөг үзэлтэй байх зайлшгүй хэрэгтэй. Бид алдаанаасаа суралцаж байж амжилтад хүрдэг. Үүнийг бид гал эрмэлзэлтэй холбох хэрэгтэй юм. Миний алдаа миний гал эрмэлзэл, хүсэл мөрөөдлийг тэтгэгч хүчин болох учиртай юм. Өөрөөр хэлбэл би алдаанаасаа суралцаж гал эрмэлзлээ улам бадраах хэрэгтэй болохоос, алдаанаасаа болж гал эрмэлзлээ унтрааж буцах ёсгүй. Энэ л хэзээ ч бууж өгөхгүй байх чанар билээ. Миний ойлгосноор дараагийн чухал зүйл бол өөдрөг үзэл юм. Бид бүгд амьдралд маш олон сонголт, боломжтой учирдаг хирнээ өөдрөг үзэл дутсан цагт боломжийг бэрхшээл гэж харах, зөв сонголтоос татгалзах явдал их гардаг, тиймээс бид аливаа зүйлийг өөдрөгөөр төсөөлж, сайн төлөвлөж, бодитоор хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Амжилтад хүрсэн хүмүүсээс авах сургамж нь тэдний үзэж туулсан амьдрал, давж гарсан бэрхшээл байдаг гэж би боддог. Тэд аливаа зовлон бэрхшээлийг өөдрөгөөр төсөөлж бэрхшээлээс боломжийг олж харж байж амжилтад хүрсэн байдаг. “эцэст нь хүний дотоод гал эрмэлзлийг асаах суурь үндэс нь өөдрөг үзэл, чин сэтгэл юм.”

Сэтгэгдэл бичсэн:

1-р үеийн тэтгэлэгт оюутан К.Алтынбек



НАР ТЭТГЭСЭН МӨРӨӨДӨЛ

Шинэ Монгол эрдмийн хүрээлэнгийн үүсгэн байгуулагч Ж.Галбадрах захирлын мөрөөдлөө биелүүлж, сургуулиа үүсгэн байгуулсан тухай ном юм. Уг номыг Шинэ Монгол гэдэг соёлыг танилцуулахын тулд хоёрдугаар жилийн тэтгэлэгт оюутнууддаа уншуулах ном болгон сонгодог.



ДЭЛХИЙН ТҮҮХ МЭНДЭЛСЭН НЬ

Монголчууд бид түүхээ мэдэхгүй хүнийг ойд төөрсөн сармагчинтай зүйрлэж ирсэн билээ. Монголын түүхийг олон талаас нь харж бичсэн Японы нэрт эрдэмтэн дорно дахин судлаач Окада Хидэхиро (1931-2017) –ийн бичсэн энэхүү номыг 3,4-р курстээ суралцаж буй оюутнууддаа уншуулдаг юм.

“Хүн аливаа зүйлийн бүтсэн

үнэ цэнэ түүхийг мэдэх тусмаа улам л илүү хайрлан хүндэлдэг.

Өчүүхэн бага зүйлчгэсэн чамгүй хөдөлмөрөөр бүтсэн л байж таарна.

Энэ номыг уншаад хамгийн

түрүүнд надад уулзалт болдог

газраа, энэ сургуулийг, тэр бүү хэл өрөөнийхөө бүхий л юмсыг энэ дотор ажилладаг хүмүүсийг хайрлах, хүндлэх сэтгэл эрхгүй ихээр төрж байв. Багшийн маань их хичээл зүтгэл, олон хүний сайхан сэтгэл хөдөлмөрөөр бүтсэн энэ “Тэр бүл”-д харьяалагдаж байгаа даа би маш их баяртай байна.”



Сэтгэгдэл бичсэн:

2-р үеийн тэтгэлэгт оюутан Э.Сувдаа



“Дэлхийн түүхийн хамгийн оргил чухал үеүүд, мөн хэрхэн дэлхийн түүх манай үндэстнээс эхлэх болсон талаар маш товч бөгөөд



ойлгомжтойгоор тайлбарласан ном юм. Дэлхийн түүхийг улс орон бүр тус тусдаа бичиж болох байсан ч хаа нэг газраа заавал Монгол хэмээх үндэстэнтэй холбогдсоор байсан тул хамгийн гол зангилаа болж буй Монголын түүхээр утгыг нь зангидаж түүхийг эхлүүлсэн талаар мэдэж авсан.”

Сэтгэгдэл бичсэн:

1-р үеийн тэтгэлэгт оюутан Б.Итгэлт

НОМ УНШИХ НОМ

Номыг хэрхэн яаж зөв унших вэ гэдгийг тэтгэлэгт оюутнууддаа хүргэхийн тулд “Ном унших ном”-ыг 3 дахь жилийн унших номоор сонгосон билээ.



ТОГЛООМЫН ДҮРЭМ

Бид сургуулиа төгсөөд амьдралд хөл тавьдаг. Нийгмийн бичигдээгүй дүрмийг суралцах зорилгоор “Тоглоомын дүрэм” номыг унших номынхоо жагсаалтад оруулсан.

Номон дээрх нэгэн зүйрлэл намайг нэлээн бодолд автахад хүргэсэн юм. Тэр нь миний муу муухай талыг ялгадсаар зүйрлүүлсэн явдал юм. Аливаа асуудлыг шууд утгаар нь ойлгодог над шиг хүнд иймэрхүү зүйрлэл ихээхэн анхаарал татдаг. Гэвч түүний



“Ном унших нь бидэнд очоогүй газраа очиж, уулзаагүй хүнтэйгээ уулзах боломж олгодог.

Бид нэгэнт л номыг цаг заваа зарцуулан уншиж байгаа

учир номоос нэг ч гэсэн зүйлийг ойлгож үлдвэл сая зорилго биелнэ. Мөн номыг сошиал медиагаар явж буй мэдээллүүд сэтгэгдлээр дүгнэх нь буруу. Тэд мэдлэгээрээ эсвэл мэдрэмжээрээ бичсэнийг бид мэдэхгүй. Тийм учраас бид үнэн зөв эх сурвалжаас номын тухай мэдээллийг авах хэрэгтэй.”



Сэтгэгдэл бичсэн:

3-р үеийн тэтгэлэгт оюутан Э.Уугантуяа

эвгүй хэлбэр, үнэрээс нь авч үзвэл хүний биед оршиж байгаагаар нь муу муухай талтай нь зүйрлэж болмоор ч юм шиг. Тийм ч бай, үгүй ч бай энэ зохиогчийн хэлэх



гэсэн санааг тийм ч их гажуудуулаагүй гэж бодож байна. Учир нь нэг их удалгүй зохиогч аливаа ухагдахуун хүн бүрд харилцан адилгүй утгатай гэдгийг дурдсан бөгөөд үүгээрээ бүгдийг тайлбарлах шиг. Зохиогчийн ярих гэсэн санаа нь хүний сэтгэл гэдэг яг л мөсөн уултай адил, биднээс нуусан хэсэг байх бөгөөд түүнд сайн сайхан ч тал бий, мөн муу муухай ч тал бий. Тэр талуудыг нь хүлээн зөвшөөрөх нь хамгийн чухал санаа юм.



Сэтгэгдэл бичсэн:

4-р үеийн тэтгэлэгт оюутан Ж.Нямдаваа

Мабүчи олон улсын тэтгэлэгийн сан /Mabuchi International Scholarship foundation/ Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль, Монгол дахь Мабүчи тэтгэлэгийн төгсөгчдийн холбоо хамтран Монголын дотоодын хувийн болон улсын их сургуульд суралцаж буй сурах чин хүсэл эрмэлзэлтэй боловч санхүүгийн хувьд боломжгүй оюутныг дэмжих зорилгоор урт хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй, хүүгүй тэтгэлэгийг жил бүр 1-р дамжааны 15 оюутан, 3-р дамжааны 15 оюутан тус тус олгодог бөгөөд

ҮНДСЭН ШАЛГУУР НЬ:

- Монгол улсын дотоодын их сургуулийн 1 болон 3-р ангид элсэн суралцаж буй сурах чин хүсэл эрмэлзэлтэй боловч санхүүгийн хувьд сургалтын төлбөр төлөх боломжгүй.
- Тэтгэлэгийн эргэн төлөлтийг оюутан өөрөө буцаан төлөх бүрэн итгэл үнэмшилтэй байх, хэрвээ эргэн төлөлт хугацаанаас хэтрэх төлөөгүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч бүрэн хариуцах болно.
- 1-р ангийн оюутны хувьд: Ерөнхий боловсролын гэрчилгээний голч дүн 80% ба түүнээс дээш, элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн хэмжээст оноо нь тухайн жилийн дундажаас тус бүр 100 оноо илүү байх
- 3-р ангийн оюутны хувьд: 1, 2-р ангийн дүнгийн голч оноо 3.2 ба түүнээс дээш байх ёстой.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ


- Тэтгэлэг хүссэн өргөдөл, анкет \ хавсралт хаягтын дагуу\
- Тэтгэлэг хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- “Миний ирэх 10 жил ба мөрөөдөл” сэдвийн дагуу тэтгэлэг горилогчийн бичсэн эсээ. Эсээг А4-н 2 хуудсанд багтаах бөгөөд WORD дээр шивсэн байна.
- Тэтгэлэгийн эргэн төлөлтийг бүрэн батлан даах эцэг эх, асран хамгаалагчийн орлогыг тодорхойлох бичиг баримтын хуулбар. Үүнд: Ажлын болон цалингийн тодорхойлолт, Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, батлан даагч нь өндөр насны тэтгэвэр авдаг бол тэтгэврийн дэвтрийн хуулбар.
- 1-р ангийн оюутан Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар, Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн хуулбар.
- 3-р ангийн оюутан сурч буй сургуулийн 1, 2-р ангийн дүнгийн тодорхойлолт





НИЙТ ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДСАН


21 **8** **18**
АЙМАГ **ДҮҮРЭГ** **ИХ, ДЭЭД**
СУРГУУЛЬ




2015-2020 ОНЫ ХООРОНД 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД НИЙТ

\$647,000 буюу **ЭРГЭН ТӨЛӨЛТ**
₮1.8 тэрбум **96%**

НИЙТ ТЭТГЭЛЭГТ ОЮУТНУУД ЖИЛ БҮРЭЭР



НИЙТ МЕНТОР ЖИЛ БҮРЭЭР



НИЙТ
МЕНТОР **90**

НИЙТ ОЮУТНЫ ТОО

196

Тэтгэлэг
аваад төгссөн
оюутны тоо

78+

Тэтгэлэг
авч байгаа

96

Эргэн төлөлт
хийж буй

57+

Ажиллаж
буй салбар

10+



Мабүчи олон улсын тэтгэлгийн сангийн 2019 оны 9 сарын 12-ны төгсөх курсын тэтгэлэгт оюутнуудын уулзалт дээр үүсгэн байгуулагч Мабүчи Такаичийн лекцээс онцлох эшлэлүүдийг орчуулан хүргэе.

Зөвхөн хоолоо олж идэх зорилгоор ажиллах нь дэндүү уйтгартай бөгөөд хайран юм. Том зорилготой бай.

Хүний хобби сонирхол гэдэг бол хүчээр хийлгэдэг зүйл биш өөрийн дураар хийдэг зүйл. Дуртай

зүйлээ хийж байгаа учир ажил тарах цаг болох үгүй нь ямар ч хамаагүй.

Энэ амьдрал дээр тундаг зүйлийг хийж бүтээдэг нь тусгай хүмүүс биш зүгээр л мэдрэмжтэй хүн байдаг. Өөрөөр хэлвэл ажиллах зорилго нь төнгө олохын тулд биш юм.

Мөнгөний төлөө ажиллаж эхэлсэн цагаас хүний хөгжил зогсдог.

————— Мабүчи Такаичи

**Шинэ Монгол - Мабүчи Сангийн үүсгэн байгуулагчдын нэг
Ж.Галбадрах багшийн тэтгэлэгийн талаарх үзэл бодлыг
тэмдэглэл болгон хүргэж байна.**

Би энэ тэтгэлэг гэдэг зүйлийн үнэ цэнийг сайн мэддэгийн хувьд хэдэн зүйл тэрлэж бичихээр шийдсэн юм. Мөн манай Шинэ Монголыг төгсөөд гадаад, дотоодод сурч буй шавь нар маань санаачлаад Шинэ Монгол-Мабүчи Сан байгуулсантай холбогдуулж тэдэнд хандаж хэдэн үг хэлэх гэсэн юм.

Өнөөдрийн намайг бий болгосон нэгэн хүчин зүйл бол яалт ч үгүй тэтгэлэг хэмээх энэхүү ид шидтэн юм. Би яг тэтгэлэг гэдэг ойлголтыг шууд тодорхойлоод хэлчихэж зүрхлэхгүй байна л даа. Энэ бол ихэнхийн ойлгож байгаа шиг зүгээр нэг шагналын мөнгө, мөнгөн дүн бол огт биш.

Өөр дээрээ жишээ авч тэтгэлгийн тухай тодорхойлохыг оролдъё. Би 4-5 удаа их бага хэмжээний тэтгэлэг авч байсан ба тэдгээр тэтгэлгийн агуу их хүч чадлын талаар гайхамшигтай ид шидийн талаар сэтгэгдлээ бичих гэсэн юм.

1. Анхны тэтгэлэг маань 1.5 жилийн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад зориулан Японы засгийн газраас өгсөн тэтгэлэг 1995 оны 10-р сар.

Эхэндээ би энэ тэтгэлгийг мөнгө, бүр асар их мөнгө л гэж харж байлаа. Сарын 150.000 иен, 1.5 жилд 2.700.000 иен буюу 27.000\$. Би тэтгэлгээ мөнгө гэж харж байсан учраас сурах хугацаандаа зарлага бага гаргаад, тэтгэлгээсээ хурааж байгаад, жаахан мөнгөтэй ирнэ гэсэн тов тодорхой зорилготой, үүрэгтэй Японыг зорьж

байлаа. Мэдээж зардал бага гаргахын тулд гэр бүлээ орхиж явна.

Гэтэл Японд очоод тэр улсын хөгжлийг хараад, буруу бодож байснаа ойлгосон. Мөнгө хурааж өвөртөлж харих биш, энэ тэтгэлгийн ачаар үр хүүхдэдээ Япон орныг үзүүлэх боломж байгааг олж харсан юм. Шууд л 6 сарын дараа 4 охин, эхнэрээ дуудлаа. Аав, эгч, эхнэр, найз нөхөд гээд олон хүн эсэргүүцэж байсан. Тэд юу гэж бодсон гэвэл, хүүхдүүддээ Япон үзүүлэх нь зөв ч, зургаагийн зургаан ам бүлээ тэжээж чадах уу? гэдэгт санаа нь зовж байсан. Би тэдэнд ганцхан хариулт өгч байлаа. Би чинь засгийн газрын том тэтгэлэгтэй хүн шүү дээ гэж. Үнэндээ тэр хүмүүсийн хэлж байсан үнэн болохыг гэр бүлээ Японд авч ирсний дараа л ойлгосон. Мөнгөгүй болж, хүнээс мөнгө зээлэхийн хэцүүг ойлгож, юун хичээл хийх манатай болж байсан үе ч байсан. Гэхдээ бүр бэрхшээлийг даван туулж үр хүүхдээ Японд сургаж чадсан, тэд маань тэнд өндөр боловсрол олж чадсан.

Дүгнээд хэлбэл засгийн газрын тэтгэлэг зөвхөн надад төдийгүй, манай гэр бүлд маш том хөрөнгө оруулалт болсон 27.000\$-оор огт хэмжигдэхгүй, түүнээс хэдэн арав дахин том хөрөнгө оруулалт болсон юм. 4 охин маань өнөөдөр сайхан амьдралтай, сайн боловсролтой, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан хувь хүмүүс болцгоожээ. Үнэхээр том хөрөнгө оруулалт шүү!

2. Миний 2 дахь тэтгэлэг бол магистрын 1-р курст байхдаа гадаад оюутнуудын дунд зарласан Хигаши Нихон Хаус ХХК болон Санкей сонины нэрэмжит зохион бичлэгийн уралдаанд оролцож 500.000 иен (5000\$)-ээр шагнуулсан тэтгэлэг байсан юм.

Дээр дурдсан тэтгэлэгтэй 1.5 жил харвасан сум шиг л өнгөрч билээ. Тэр үед би нэг зүйлийг хийж чадсан, нэг зүйлийг хийж чадаагүй. Чадсан зүйл маань хувийн зардлаар магистрт суралцах шалгалтанд тэнцсэн, хийж чадаагүй нь магистрт сурах үедээ тэтгэлэг олж явдал юм.

Анх гэр бүлээ авчирчихаад тэтгэлэгтэй ч гэсэн хэцүү байна л даа гэж бодож байсан маань магистрт орсны дараа улам хүндэрсэн юм. Мэдээж шүү дээ, сар болгон авдаг байсан нөгөө том тэтгэлэг маань ор сураггүй алга болсон юм шүү дээ. Тэгээд би гэр бүлээ тэжээхийн тулд жинхэнэ ажлын мал болно гэдэг болсон доо, хөөрхий. Өдөрт 3 ажил хийнэ, 4-5 цаг унтана гээд. Одоо заримдаа тэр үеээ бодохоор хар дарсан зүүд шиг санагддаг.

Эргээд тэтгэлгийнхээ ярианд орьё. Зохион бичлэгийн уралдаанд сониноор зарлагдаж, мөрөөдлийнхөө, тухай бичих болсон юм. Юу бичих билээ? Бодоод л байлаа, нээрээ би чинь багш юм чинь нутагтаа харихаараа сургууль нээж цөөхөн ч гэсэн хүүхдэд чанартай боловсрол олгохыг хүч байна гээд хөнгөхөн биччихлээ. Азаар 850 гару хүнээс 40-д шалгарч гар дээрээ 500.000 иен авах боллоо. Токиод очиж гардаж авах үедээ аминдаа л их л зүйл хэлэхээр бэлдэж очсон ч индер

дээр гараад юу ч хэлж чадахгүй, зүгээр л гацаж гацаж “баярлалаа” гэдэг ганцхан үгийг л хэлээд бууж байсан юм. Их ичиж билээ. Хүн үнэхээр их баярлахаар тэгж мэдрэлийн сааталд орж толгой тархи нь хов хоосон болдгийг ийм байдалд орж байгаагүй хүн ойлгохгүй байхаа.

Би үнэндээ яг тэр үед мөнгө л боддог болчихсон байсан гэхэд хилсдэхгүй. Ер нь бол шантарч эхлээд байв. Магистраа яаж ийж дүүргээд Монголдоо хурдан харихыг боддог болсон байв. Шөнө 01 цагт ажлаасаа гэрлүүгээ дугуйгаар харьж явахдаа аяга угааж норсон цамц минь хөлдчихсөн, дугуй маань цасан дунд зоогдчихсон байхад ганцаараа хэнгэнэтэл уйлж ч байсан. Гэтэл арчаагүй энэ байдлаас намайг дээр тэтгэлэг л салгаж өгсөн. Мөн надад нэг хүчтэй сэдэл төрүүлсэн юм.

“Хэрвээ чи тэтгэлэг авахдаа хэт баярлаад, сэтгэлээ олигтой илэрхийлж чадаагүй юм бол, мөрөөдөл болгож бичсэн зүйлээ л бодитоор биелүүлж харуулах хэрэгтэй” гэсэн хүчтэй мэдрэмж төрсөн, Үнэхээр ч би тэр хүчтэй мэдрэмжийн ачаар 3 жилийн дараа мөрөөдлөө биелүүлж сургуулиа байгуулчихаад Накамура захирал дээр очиж билээ. Гэтэл Накамура захирал гуай яасан гээч. Миний өмнөөс тэр хүн нулимс гаргаж, үнэхээр баярлаж байгааг харахад, үнэхээр миний сэтгэл хөдөлсөн. Накамура захирал надад нэгэн түүх ярьсан юм. Гадаад оюутанд зориулсан тэтгэлгийг 8 жил дараалан зарласан бөгөөд чи бол отгон оюутнуудын нэг. Би мөрөөдлөө биелүүлдэг оюутан гаргахыг их

хүлээдэг байсан. Гэвч эргэж бидэн рүү холбогддог, мэдээлэл тайлан хийдэг нь ховор байсан даа. Гэтэл чи бол бүүр мөрөөдлөө биелүүлчхээд ирж байна шүү дээ гэсэн юм. Тэрээр цааш нь Чи бол миний мөрөөдлийн биелэл. Иймд би чамд одоо ч гэсэн дахин тусалмаар байна. гээд газар дээр нь 3 сая иен шийдэж, сургуульд маань хандив өргөх болов?

Үнэндээ тэр үед би ахиад шоконд орж, нэг буруу зүйл хийсэн мэт санагдаж, “Би таниас мөнгө авах гэж ирээгүй, таниас авсан урмын ачаар л мөрөөдлөө биелүүлж чадсандаа талархсан сэтгэлээ л хэлэх” гэж ирсэн гэдгээ тайлбарлахад, өөдөөс үг сонсохгүй, “Би мэдэж байна. Чи бас миний мөрөөдлийг биелүүлж өглөө” гэж зүтгэсээр байгаад сургуульд маань тэрхүү тэтгэлгийг өгсөн юм. Гэхдээ үнэнийг хэлэхэд, энэ мөнгө асар их цагаа олсон дэмжлэг байсан юм. Сургууль маань байгуулагдаад удаагүй байсныг хэлэх үү? Санхүүгийн хувьд ч хүнд, багш нарыг цалингаа тавьж чадахгүйд хүрээд байсан юм. 3.0 сая иен (30.000\$) гэдэг нь сургуулийн жилийн төсвөөс (21.000\$) их байв. Энэ үйл явдал надад ахиад л асар их хүч өгч, гал эрмэлзлийг маань дүрэлзүүлсэн юм. Тэгэхээр энэ тэтгэлэг гэдэг зүйлд учир битүүлэг, нэгэн гайхамшиг байгаад байгаа шиг. Хүмүүсийн мөрөөдлийг биеллээ олтол нь нөлөөлөөд ч байх шиг, нэг л гайхамшигтай.

3. Дараагийн нэг тэтгэлэг бол магистрийн 2-р курсдээ Японы Ротаричуудаас авсан Ёнэяма-ийн нэрэмжит тэтгэлэг юм. 1998. 4-1999.3 хооронд Өдөрт 3 ажил хийгээд хүмүүст

“биеэ хэмхэл вээ” гэж хүртэл хэлэгдэж байсан миний хувьд сар бүр 150.000 иен авах болсон нь зүүдэлж байна уу? гэмээр л сонин үйл явдал болов.

Энэ тэтгэлгийн онцлог нь сар бүр өөрийн харьяалагдаж байгаа ротари клубийн хуралд сууж, тэтгэлгээ клубийн ерөнхийлөгчөөсөө гардаж авна. Тэр үедээ өөрийнхөө сэтгэгдлийг 2-3 минутад хэлнэ. Би тэтгэлэг гардаж авах авах бүртээ талархаж байгаагаа чадлаараа хэлдэг байсан ч нэг сэтгэлийн гүнийх биш юм шиг санагдаад сэтгэлээ бүр л хүчтэй илэрхийлмээр санагддаг байв. Тэгээд 4 дэх удаагийн хурал дээр тэтгэлэг гардаж авах үедээ нэгэн зүйлийг клубынхаа хүмүүст амласан юм.

Би та бүхний энэ их ачийг, өөрийн мөрөөдлөө биелүүлж хариулах болно. Миний мөрөөдөл бол Монголдоо Япон хэв шинжийн ахлах сургууль байгуулах явдал юм. Гээд маш их итгэлтэйгээр, зориг золбоотойгоор тэр хүмүүст үнэн сэтгэлээсээ амлаж билээ. Гэтэл ч хүмүүс маань алга нижигнүүлээд л явчхав. За ашгүй хүмүүст миний талархсан сэтгэл хүрлээ дээ гэж дотроо баярлаж, сэтгэл онгойх шиг болж билээ.

Ямагата их сургуульд Магистраа төгсөөд би үргэлжлүүлэн Тохоку ИС -ийн докторт суралцах болсон юм. Докторынхоо сэдвээ сонгохдоо ирээдүйд хийх өөрийн ажилтайгаа холбож, удирдагч багштайгаа сайтар ярьсаны үндсэн дээр Монголын ахлах сургуулийн каррикулумын шинэчлэл гэж тогтоов . Өөрийн хүч байсан сэдвээ сонгосон тул докторын 1-р курсээс судалгаа маань эрчтэй, хурдтай, ахиц их сайтай байлаа. Тэгээд 5 сарын дараа нөгөө Ямагата хойд ротарийн

клубээс урилга ирж ойрын үеийн мэдээллээ сонирхуулаач гэсэн юм. Би ч уриалгахнаар очиж, докторын ажлын талаар болон ирээдүйд байгуулах сургуулийнхаа дүр зургийг нүдэнд харагдтал яриад, сонин сайхнаа хуваалцсан юм. Гэтэл ярианы эцэст Жанчив сан, оюутан байхдаа сургуулиа байгуулж болохгүй юу? гэдэг асуулт гардаг байлаа. Би ч Болохгүй ч юм байхгүй л дээ гээд хариултал, Чиний мөрөөдөл ийм тодорхой байгаа чинь сонирхол татаж байна, бид дэмжинэ шүү гэдэг байгаа.

Үнэхээр цаг хугацааны учрал байдаг гэдэгт би тэр үед гүнзгий итгэсэн юм. Клубт яриа хийсний дараа амралтаараа Монголд ирчхээд, нөгөө хүмүүсийн хэлсэн үг санаанд ороод, нэг өдөр зав гарган Боловсролын яам, Нийслэлийн боловсролын газар зэргээр орж, сургууль байгуулахад юу хэрэгтэй байдаг зэргийг судлах санаатай явсан юм. Гэтэл нийслэлээс 920 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын дуудлага худалдаа явагдах гэж байгаа, Түүнд ороод үзэхгүй юу? гэсэн яриа гардаг байгаа. Гэхдээ хурлын тов нь 9 сарын сүүлээр тул, би байхгүй байж таарах гээд, орноосоо аавыгаа оруулах болоод, өөрийн дотнын багш нартаа даатгаад буцсан юм. Гэтэл удалгүй, хурал болсон, манайх нэг их сүйдтэй өрсөлдөгчгүйгээр газраа авчихлаа гэдэг мэдээ ирдэг байгаа. Сургууль байгуулах зөвшөөрөл ч төвөггүй гарна гэдгийг сонсов. Цаг хугацааны тохирлоо гэж! Ингээд гялс амжуулсан хүн чинь нөгөө клубийн хүмүүстэйгээ холбогдож, би та нарт мэдээлэл хийх гэсэн юм гээд

нэг хуралд нь очихоор болов .

Нөгөө л индэр дээрээ гараад ярьж өгсөн дөө. Нөгөөдүүл маань гайхаад явчлаа. Ийм хурдан ажил эхэлж байгаад баяртай байгаа ч бодож байснаас нь их зардал гарахыг сонсоод, зөвхөн клуб гэлтгүй олон нийтийг хамруулахаар болж, Монголд сургууль байгуулах хөдөлгөөн өрнүүлэхээр болж Багана Нэгийн Холбоо байгуулав. Ингээд энэ хүмүүс намайг нуруунаас минь түлхэж, их үйл рүү оруулсан юм байна даа. Ингэж Шинэ Монгол хэмээх нэгэн сургууль байгуулагдсан түүхтэй .

Энэ ид шид шиг санагдахгүй байна уу? Үнэхээр ид шид. Сайн бодвол ротарийн тэр л тэтгэлэг энэ бүхний эхлэлийг тавьжээ. Тэр л тэтгэлгээс энэ их ид шид гарчээ. Гэхдээ тэтгэлэг болгон ийм ид шидтэй байх юм болов уу?

Би дээр 3 тохиолдол бичиж, тэдгээр тэтгэлэгт нэр өгөх гээд байгааг анзаарч байгаа байх. Их хөрөнгө оруулалт болсон, тэтгэлэг, гайхамшгийг бүтээсэн тэтгэлэг. Ид шидийн хүчтэй тэтгэлэг гээд нэрлэх гэж оролдоод байна. Гол хэлэх гэсэн санаа маань тэтгэлэг бол их шидтэй эрх хүчтэй гайхалтай зүйл юм шүү гэдгийг л хэлэх гээд байна.

Миний шавь нар, та нар минь бүгд л тэтгэлгээр л сурч байгаа. Ид шид, хүч чадал, гайхамшгийг нь мэдэрч байна уу? Хараахан мэдэрч амжаагүй хүн байвал багш нь хэдэн зөвөлгөө өгье.

Тэтгэлгийг зүгээр нэг шагналын мөнгө гэж битгий хараарай. Талх, мах, унаанд зардаг хэрэгцээний мөнгө төдий битгий бодоорой. Юуны түрүүнд энэ тэтгэлэгт маш сайн талархаарай.

Онц сурсны минь төлөө, эсвэл миний авьяасыг, амжилтыг маань үнэлж өгч байгаа гэж битгий эндүүрээрэй. Би энэ тэтгэлгийг яг авах ёстой хүн байсан гэж битгий хөөрчхөөрэй. Би Шинэ Монголыг төгссөн юм чинь ивээн тэтгэгчийн тэтгэлэг авах эрхтэй нэгэн. Тийм ч учраас авч байна. Би Шинэ Монголыг төгссөн учир Монбушод тэнцэх нь ойлгомжтой байсан, Би Америкт тэтгэлгээр сурах чадварыг угаасаа биедээ шингээж авсан байсан гэж онгирч бодуузай. Хэрэв эхнээсээ ийм бодлын аль нэгийг тээж байгаа бол тэтгэлгийн ид шидийг мэдэрч чадахгүй л болов уу?

Харин эсрэгээрээ энэ тэтгэлгийг яагаад надад өгөөд байгаа юм бол, яаж намайг сонгосон юм бол, яагаад ийм сайхан боломж надад олдоод байгаа юм бол оо? гэдгийг сайтар шүүн бодоорой. Тэгээд энэ тэтгэлэг олгож байгаа засгийн газар, компани, хувь хүмүүст яаж сэтгэлээсээ талархлаа илэрхийлэх вэ? гэдгийг чин үнэн сэтгэлээсээ бодож байвал наад тэтгэлэг чинь ид шидийг авчрах болно. Итгээрэй!

Эцэст нь чи хүнээс авсан бол хэн нэгэнд бас өгч байгаарай . Авсныгаа бүгдийг нь гэсэн үг биш, өчүүхэн хэсэг нь байхад болно. Чи сард 1000\$, жилд 12000\$ тэтгэлэг авч байгаа бол хэн нэгэнд зориулаад ердөө 1/100 хувь буюу 100\$-ийг жилд хандивлаж чадах сэтгэлтэй байгаарай . Чи өнөөдөр сургуулиа амжилттай төгсөөд, төрд ч бай, компанид ч бай ажилд ороод цалинтай сайхан амьдарч байгаа бол цалингийнхаа өчүүхэн хэсэг болох, сарын 15.000 төгрөгийг хэн нэгэнд хандивлаж чадахгүй гэж үү? Жишээ нь 1.5 саяын цалинтай бол ердөө 1/1000

байна шүү дээ . Орлогын чинь ердөө 0.1%.

Одооноос залуу байхаасаа, оюутан байхаасаа ийм үйлийг эхлүүлж, ийм үйл хэрэгт оролцож дадвал ирээдүй чинь улам л гэрэлтэй байх болно. Энэ эхлэл чинь яван явсаар байгаад 100\$ өгч байгаа одоогийн чиний хүч, ид шидээр арвижиж, сая сая доллар өгдөг агуу хүн ч болж болно. Энэ бол хэн нэгэнд тусалж, тэтгэлэг өгөхийн ид шид! Энэ тухай дараа бүгдээрээ үргэлжлүүлэн ярилцаж болно шүү .

За хайрт шавь нартаа хамгийн сайн сайхныг хүсье! Та нарынхаа эхлүүлсэн ажилд амжилт хүсье!



5 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

Шинэ Монгол- Мабүчи сангийн 5 жилийн Ойн хүрээнд тэтгэлэгт хөтөлбөрийн төгсөгч, оюутнууд болон сангийн ажилтнууд хамтран “Нийгэмд ээлтэй оюутан залуус” уриан дор зохион байгуулж буй төсөл хөтөлбөрүүдээ танилцуулъя.

“КИРА КИРА” ПОДКАСТ

Сангийн тэтгэлэгт оюутнууд, төгсөгч, менторууддаа зориулж “Кира кира” подкастыг бэлтгэн хүргэж эхэлсэн. Эх орныхоо сайн сайхан ирээдүйд хувь нэмэр оруулах хүндтэй үүргийг хүлээн, мөн тэдний маань ирээдүй гэрэлтэж байхыг хүсэн бэлгэдэж Япон хэлний “Кира кира” буюу “Гялтганах” хэмээх утгаар ийн нэрлэсэн. Тус подкастын эхний дугаарт Юу Эс Пи Монгол компанийн гүйцэтгэх захирал Ш.Буянжаргалыг урьж “Тоглоомын дүрэм” номын талаар ярилцлаа.



“ЭМНЭЛГИЙН ӨРӨӨ ТОХИЖУУЛЛАА”

Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс засал, гэмтлийн тасгийн хүүхдийн 1 платыг тэтгэлэгт оюутнууд, Шинэ Монгол эрдмийн хүрээлэнгийн хамт олны дэмжлэгтэйгээр засаж тохижууллаа. Үүнд хана, таазыг сэргээн засаж, хөшиг тогтоон бэхэлж, хананд чимэглэл болгон хүүхдийн танин мэдэхүйд зориулан ханын зураг зурж, ном болон тоглоомуудыг хандивлалаа. Төв аймгийн мэс заслын эмч Ганбаяр баярласнаа илэрхийлж “Хөөрхий



өвдсөн хүүхдүүд маань энэ гоё өрөөндөө орж ирээд баярлаж, түр ч болов сатаарна даа” хэмээн хэлсэн нь бидний сэтгэлд улам олон сайн дурын ажлууд хийх галыг асааж өгсөн юм.

72 ДУГААР СУРГУУЛИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙГ ТОХИЖУУЛАХ

Тус сургууль нь Чингэлтэй дүүргийн Хайлаастад байрлалтай бөгөөд 1-12 ангийн 2100 гаруй хүүхэд суралцдаг.

Бид нийтэд хүртээмжтэй байх тал дээр анхааран сургуулийн гадаад орчныг тохижуулан хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Хүүхдийн тоглоомын талбайн зөөлөн резинэн дэвсгэр, хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх тоглоом суурилуулах, настай хүмүүс салхилан амрах амралтын сүүдрэвч барихаар төлөвлөж байна.



Манай сангаас Монголд анхлан нэвтрүүлсэн энэхүү “Менторшип тогтолцоо” гэдэг нь оюутан нэг бүрийг хичээл сурлага, карьер төлөвлөлт, амьдралын гээд бүхий л талаар зөвлөн чиглүүлэх ах эгчтэй байх систем юм. Ментор нь Японд суралцаж төгссөн Шинэ Монгол сургуулийн төгсөгчид байдгаараа онцлогтой.

Менторууд нь Шинэ Монгол - Мабучи сангийн үйл ажиллагааг дэмжих зорилготой МАМИСА (Монгол дахь Мабучи тэтгэлгийн төгсөгчдийн холбоо)-н гишүүд бөгөөд тэтгэлэгт оюутныг дааж авснаар хичээл сурлага төдийгүй хувь хүний хөгжилтэй холбоотой зөвлөгөө өгөх үүрэгтэй.

Сан нь тэтгэлэгт оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг өгөөд зогсохгүй хувь хүний хувьд төлөвшүүлэн, хөгжүүлэхэд анхаардаг. Сайн төлөвшсөн хүнийг бэлтгэн, улсын хөгжилд хувь нэмэр оруулах залуусыг бэлдэн гаргахад менторын үүрэг оролцоо их байдаг. Нийгэмдээ олон сайн зүйлийг хийж бүтээх сайн өөрчлөлт хийх гэсэн сэтгэлтэй, мэдлэг боловсрол өндөртэй, зөв төлөвшилтэй хүн нь улсын маань гол нөөц баялаг болдог.



1 ментор 2 жил болон 4 жил тэтгэлэг авах хоёр оюутанг дааж авдаг. Ментор ментий байнга холбоотой байна, хичээл сурлагад нь анхаарал тавин амжилттай үр дүнтэй сурахад чиглүүлэн зөвлөх үүрэгтэй байна. Сан нь ментортой нягт холбоотой байж, оюутны талаар мэдээлэл хуваалцан санал бодлыг нь сонсох, хэрхэн үр дүнтэй зөвлөгөө өгөх талаар хамтран ажилладаг.

Ментор ментий нь сэтгэл санааны хувьд, мөн бусад бүх л зүйл дээр хоорондоо холбоотой байж бие биендээ туслалцаа үзүүлэх боломжийг олгодог. Энэ нь сайн зөвлөгч, сайн багш, сайн найзтай болж байна гэсэн үг юм. Насан туршийн нандин холбоотой номын ахан дүүс болдог нь хамгийн үнэ цэнэтэй.

МЕНТОРУУДЫН СЭТГЭГДЛҮҮД

Хөгжихөө зогсоож болохгүй гэх “Өлсгөлөн зан”-г байнга мэдрүүлдэг. Өөрөөр хэлбэл, номын дүү нартаа том гишгүүр болохын тулд өөрөө хичээх шаардлагатай болсон. Бүх менторуудыгаа, хамтдаа улам хөгжиж чанартай, өндөр гишгүүр болцгооё хэмээн уриалж байна.

5-р үеийн ментор **Э. Отгонбилэг**



Хамгийн түрүүнд дүү нартаа өөрийн чадах зүйлээрээ туслаж байгаа нь хамгийн сайхан. Уулзалтаар дамжуулан олон сайхан яриануудыг сонссоноор хувь хүн талаасаа хөгжиж, эрч хүчээр цэнэглэгддэг. Тийм ч учраас аль болох уулзалтууддаа идэвхитэй оролцохыг боддог доо.

2-р үеийн ментор **П.Номинцэцэг**



ЭРГЭН ТӨЛӨЛТ, ЭРГЭХ ХОЛБОО

奖学金授予式

Тэтгэлэгт оюутнууд их дээд сургуулиа төгсөөд 1 жил ажилласны дараа эргэн төлөлтөө хийж эхэлдэг. Тэтгэлэг авсан хугацаатай адил хугацаанд сар бүр сангаас батлан гаргасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу тэтгэлгээ төлж дуусгадаг.

Эргэн төлөлт нь тэтгэлэгт оюутнуудыг төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай болох дадалд сургахын зэрэгцээ хариуцлагатай, хэлсэндээ хүрдэг итгэл даасан хувь хүн болоход нөлөөлдөг.

Сургуулиа төгсөөд шууд эргэн төлөлтийг эхлүүлэлгүй 1 жилийн дараагаас буюу ажлын байран дээр дасах, ажлаа ойлгон танин мэдэх хугацаа олгодог онцлогтой. Ажил мэргэжилдээ дадлагашин нийгэмд хувь нэмрээ оруулах үүрэг хүлээхийн сацуу дараа дараагийн үеийн оюутан дүү нартаа боловсрол эзэмшин чадварлаг боловсон хүчин болох боломжийг олгодог тасралтгүй үргэлжлэх холбоог үргэлжлүүлэх эрхэм үүргийг хүлээдэг билээ.

Тэтгэлэг авагчаас тэтгэлэг олгогч болон итгэл хариуцлагыг дараагийн үедээ шилжүүлдэг.

Хүүхэд өсөж том болоход
эцэг эхийн тусламж
маш их хэрэгтэй шиг
хүн болоод амьдралд
гарахад минь түүнээс минь
өөрцгүй дэмжлэг үзүүлж буй
Шинэ Монгол - Мабүчи Сандаа баярлалаа.

4-р үеийн тэтгэлэгт оюутан М.Ижилтөр



Хүн бүрд боломж үргэлж
нээлттэй байдаг. Гагцхүү
тэр боломжийг зөв цагт нь
алдалгүй ашиглах чадвал
хэмээх ирээдүй хэмээх
уртаас урт гүүр таны өмнө
гэрэлтэх болно. Энэ боломжийг бий болгосон
Шинэ Монгол - Мабүчи Сандаа баярлалаа.

4-р үеийн тэтгэлэгт оюутан Э.Халиунгоо



Тэтгэлэг олгогчид
горлигчидоосоо илүү
баяртай байсан, тэр
хүмүүсийн алсын хараа
Монголыг хөгжүүлнэ,
ирээдүйг сайн сайхныг
бий болгоход тэмүүлсэн, хүчирхэг. Надад хэн
нь ч хичээгээрэй гэж хэлээгүй ч, намайг илүү
ихээр хичээх ёстойг минь, тэр сайхан гэгээлэг
ирээдүйг хамт бүтээхэд оролцох багийн нэг
гишүүн болсныг минь мэдрүүлсэн.

4-үеийн тэтгэлэгт оюутан С.Ахерке



Спорт нь биднийг
хатуужилтай болгоод
зогсохгүй илүү
нээлттэй болгодог.
Шинэ Монгол - Мабүчи
Сангийн тэтгэлгийн нэг
онцлог нь спорт өдөрлөг юм.

4-р үеийн тэтгэлэгт оюутан Б.Цэлмэг



Шинэ Монгол - Мабүчи
Сангийн тэтгэлэг нь
хүнийг илүү үүрэг
хариуцлагатай болгодог.

**5-р үеийн тэтгэлэгт
оюутан Г.Оргилболд**



СЭТГЭЛИЙН ИЛГЭЭМЖ

Талархах сэтгэл дандаа
төрүүлдэг. Өөртөө, гэр
бүлдээ, сангийн хамт
олондоо, япончуудад, эх
орондоо гээд л бүгдэд талархаж,
хичээж явах ёстойг сануулдаг.

2-р үеийн тэтгэлэгт оюутан Э.Дуламсүрэн



Ирээдүйн боловсон хүчинд
ялангуяа бүр Монголын
оюутан залууст тусгайлан
энэхүү тэтгэлгээ олгож
байдагт чин сэтгэлээсээ
талархдагаа Мабүчи Сандаа
илэрхийлмээр байна. Япон дахь тэтгэлгийн
сангийн хамт олондоо ажил, амьдралд нь
хамгийн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе.

1-р үеийн тэтгэлэгт оюутан З. Батчимэг



Суралцах хүсэл эрмэлзлээр
дүүрэн хэдий ч санхүүгийн
боломж хомс хүүхэд
залуучуудад туслалцаа үзүүлэх
нь үеийн үед л асуудал болсоор
ирсэн. Үүнийг шийдвэрлэх ажилд
ингэж ухаалгаар, оновчтойгоор гар бие
оролцож байгаа явдалд та бүхэнд талархахгүй
байхын аргагүй юм. Энэ ажилдаа зүгээр мөнгө
тараах биш хариуцлага, хамт олон гэдэг чухал
асуудлуудыг цогцоор нь багтааж байгааг бас зөв
зүйтэй хэрэг болсон гэж боддог. Баярлалаа.

2-р үеийн тэтгэлэгт оюутан Б. Эрдэнэхүү



ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД



МОНГОЛ ДАХЬ КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖУУД

Анх 2008 оноос Японд коосэн төгссөн залуучууд санаачилан, Монголд Коосэн технологийн коллеж байгуулахыг дэмжигчдийг нэгтгэн тус төслийг эхлүүлэн, 2014 он гэхэд анхны 3 коосэн сургууль зэрэг байгуулагдсан. “20 настай инженер” гэсэн концепц бүхий 15 настайгаас 5 жилийн хөтөлбөрөөр инженерийн дээд боловсролыг олгодог Япон улсын онцгой “брэнд” тогтолцоо юм.

Бид 2019 оноос шинээр нэвтрэн хэрэгжиж байгаа энэхүү тогтолцоо, онцгойлон инженерийн салбарыг дэмжих зорилгоор Монголын Коосэнуудад суралцаж буй 10 оюутанд тусгайлан тэтгэлэг олгодог болсон. Ингээд жилд нийт 41 оюутанд тэтгэлэг олгодог болов.



ЭМОС КЛУБ

“Эмос” нь 15 жилийн тэртээ гадаадад суралцаж байсан монгол залуус цахимаар холбогдон, эх нутагтаа байгаа оюутан залуус, дүү нартаа зориулж “Өөрийгөө хөгжүүлэх” номыг хамтран гаргаснаар байгуулагджээ. Түүнээс хойш тус клубийнхэн “Мэргэжлээ зөв сонгоход тань”, “Япон хөтөч”,

Инамори Казуогийн “Амжилтад хүрэх гал эрмэлзэл” (орчуулга), Мортимер Адлер нарын “Ном унших ном” (орчуулга) зэрэг номыг уншигчдын хүртээл болгосон бөгөөд сангийн зүгээс номтой уулзалтаар уншигдах номыг голлон Эмос клубын эрхлэн гаргасан номоос сонгон авч уншуулдаг.

Монголын хүүхэд залуусын оюуны хөгжил, хүмүүжилд хувь нэмрээ оруулахаар зорин үйл ажиллагаа явуулдаг тус байгууллагатай бид байгуулагдсан цагаасаа хамтран ажиллаж ирсэн.



Rotary
Club of Khuree



ХҮРЭЭ РОТАРИ КЛУБ

Хүрээ Ротари клубын гишүүдэд Ж.Галбадрах багш сангийн үйл ажиллагааг танилцуулан, үйл ажиллагаандаа урин оролцуулснаас хамтын ажиллагаа эхлэлтэй. Жил бүр тэтгэлэгт тэнцэж чадаагүй оюутнуудаас 31 дэх оюутанг клубын гишүүд сонгон Хүрээ ротари клубын нэрэмжит тэтгэлэг олгодог.

Өнөөг хүртэл нийт 2 жил суралцах 4 оюутанд тэтгэлэг олгоод байгаа бөгөөд ментороор 2 гишүүн хариуцан ажиллан амжилттайгаар хамтын ажиллагаа үргэлжилж байна.



SHINE MONGOL
MABUCHI
FOUNDATION